



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/120

Биндэр сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дахь заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57 – д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдсан 1 иргэнд 1550 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2009 оны 09 тоот захирамжийн 140 дэх хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц. ДЭМБЭРЭЛСАЙХАН

Сумын Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын
12 өдрийн 420 тоот захирамжийн хавсралт

№	Газар өмчлөгчийн				Өмнөх захирамжийн			
	Ургийн овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	Боржигон	Лувсангомбо	Чинбат	МБ63122216	2005.05.18	A/9	13	140

№	Өмнөх газрын			Одоо	
	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Хаяг	Нэгж талбарын дугаар	Хаяг
1	23100003133	1442	Сансар	1583	Сансар-8, 818